

Даван тунгалаг

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН

МҮҮХ



2020 он



Хүчирхийллийн эсрэг
үндэсний төв



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг



Мянган эрвээхийн дэвэлт өөргөмөлтийн шуургыг дэгдээнэ

Энэхүү цахим номыг Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр бүтээв.

Энэхүү номын агуулгатай холбогдсон санал хүсэлтийг Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн mongolcav@gmail.com хаягаар хүлээн авахдаа таатай байх болно.

© Зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.

ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ТӨВ

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, 40-р байрны 03, 06 тоот:
Утас: 70119949, Зөвлөгөө өгөх утас: 96490505
И-мэйл: mongolcav@gmail.com
Вэб сайт: www.safefuture.mn



Та өөрийгөө болон
ойр дотны хайртай
хүмүүсээ хамгаалж
МАСКАА
ЗҮҮГЭЭРЭЙ.



ӨМНӨХ ҮГ

Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод 1995 оноос хойш цогц үйлчилгээг үзүүлж, хууль эрх зүйн орчныг хохирогчдод ээлтэй болгох бодлогын нөлөөллийг 25 жилийн турш тасралтгүй явуулж ирсэн иргэний нийгмийн анхдагч байгууллагын нэг юм.

Өнгөрсөн хугацаанд 21000 гаруй үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлсэн. Бид үйлчлүүлэгчдээ дэмжих бүлэг болон манлайллын хөтөлбөрөөр дамжуулан чадавхижуулж хэвийн амьдралдаа эргэн ороход нь тусалдаг.

ХЭҮТ нь хүчирхийлэл, дарамтыг даван туулахыг эрмэлзэж байгаа хүмүүсийн өөрсдийнх нь оролцоо, дуу хоолойг илэрхийлэх явдлыг чухалчлан үздэг. 2003 онд анх удаа “Даван туулагчдын бага хурал”-ыг даван туулагч хүүхэд, эмэгтэйчүүд өөрсдөө зохион байгуулж, илтгэлээ тавьж, хэлэлцүүлэг өрнүүлж байсан түүхтэй.

Бид үйлчлүүлэгчдийг чадавхижуулах хөтөлбөрөө “Мянган эрвээхийн дэвэлт өөрчлөлтийн шуургыг дэгдээнэ” гэсэн нэртэйгээр явуулдаг ба энэ нь хүчирхийллийг даван туулахын тулд ганцаар тэмцэх биш, бие биенээ дэмжин тусалж, эвлэлдэн нэгдэхийн ач холбогдлыг илэрхийлдэг. Үүгээр ч зогсохгүй хүчирхийлэл давтагдахаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд хүн бүрийн оролцоог хангаж, олон нийтийн хөдөлгөөн өрнөн дэлгэрэхийн билгэдэл гэж тайлбарладаг.

Энэ удаад манай үйлчилгээнд хамрагдсан даван туулагчид өөрсдийн түүхээрээ дамжуулан хүчирхийллийн хор уршиг, хүчирхийллийг даван туулах үйл явц нь хохирогчоос ямар их сэтгэлийн хат, тэвчээр шаарддаг, яагаад хөндлөнгөөс албан болон албан бус туслалцаа, дэмжлэг хэрэгтэй байдгийг харуулахыг зорилоо.


Даван туулагч гэдэг нь аль нэг байгууллага, мэргэжилтэнд хандаж гарах гарцаа хайж байгаа, зөвлөгөө тусламж авах, шаардлагатай үйлчилгээнд хамрагдах зэрэг бүхий л үйл явцад оролцож байгаа хохирогч юм.

Таны өөрийн болон таньдаг хэн нэгний амьдрал энэ түүхтэй ойролцоо мэт санагдаж байгаа бол Та бүү эмзэглээрэй! Бас бүү буруутгаарай.

Харин түүнд зайлшгүй хэрэгтэй мэдээллийг өгч, хаана, хэнд хандаж туслалцаа дэмжлэг авах боломжтойг хэлж туслаарай.

“Танай байгууллагын хаалган дээр ирээд би 7 удаа буцаж байлаа. Гэхдээ хэзээ нэгэн цагт орж, бүх асуудлаа хуваалцаж, туслалцаа хүснэ дээ л гэж боддог байв. Харин зориг гарган уулзаж байгаагаараа хүчирхийллийг даван туулах эхний алхамаа хийж байна гэдгээ ойлголоо...”

Зөвлөгчийн тэмдэглэлээс



ХҮЧИРХИЙЛЭЛ ДОР ӨССӨН ХҮҮХДҮҮД ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧ БОЛДОГГҮЙ...

Хүн болох хувь тавилан юутай их аз завшаан болохыг сонсож өссөн бага нас минь саяхан санагдана. Хүүхэд бүхэн инээж хөөрч баяр жаргалтай байхыг харах надад сайхан байсан ч миний туулж буй амьдралд инээх шалтгаан ховорхон байдаг байлаа.

Саяхан Чингэлтэй дүүргийн нэгэн дунд сургуульд 7-н настайдаа анх сурагч болсон. Ангидаа их сэргэлэн цовоо, хөдөлгөөнтэй, багшийнхаа хайртай шавь, анги хамт олондоо нэр хүндтэй, хичээлдээ дуртай охин байлаа. Суралцаж байх хугацаанд аавын минь тус дэм, анхаарал надад маш их үгүйлэгдэж байсан.

Энэ бүхнээр миний амьдралын бэрхшээл дуусдаг байсансан бол хичнээн сайхан. Гэвч бяцхан бие минь даахааргүй сэтгэлийн зовлон айдас дарамт дунд өссөндөө.

Айлын хүүхдүүд өглөө босоод сайхан амттай хоол, шинэ хувцас, ирээдүйн хүсэл мөрөөдлөө бодон сэрдэг бол миний хувьд өнөөдөр хэрүүл битгий болоосой, аав архи битгий л уугаасай,

ангийхан минь намайг ийм хэцүү амьдрал туулж буйг маань битгий л мэдчихээсэй гэсэн зовинолоор дүүрэн өглөөг угтаж, өдөржин энэ л бодлоо тээсээр шөнийг угтдагсан.

Миний хувьд гэр маань хэзээ ч айдасгүй амар амгалан газар байгаагүй. Тиймдээ ч боломж л гарвал ангийнхаа хүүхдүүдийнд очиж хичээл давтах нэрээр өдрийг өнгөрүүлдэг байлаа. Ээж маань ч энэ бүгдийг ойлгож намайг явуулахаас цаарагладаггүй байсан юм.

Ээжийнхээ бидэнтэй хамт туулж өнгөрүүлсэн амьдралыг бодохоос сэтгэл өвддөг. Харсан хүний нүд хальтармаар хүнд өдөр хоногууд байсан. Ээж бидний төлөө цаг наргүй хөдөлмөрлөж амьдралаа зориулж байсан ч үүний шагнал гэж хэзээ ч байгаагүй. Үргэлж л зодуур, дарамт, доромжлол дунд амьдарсан ээжид минь баярласан өдрүүд өдрийн од шиг ховорхон байсан.

Ганц ч биш олон удаагийн давтамжтайгаар хүчирхийллийн хохирогч, гэрч болж хамгаалалт

хүсэн Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хамгаалах байранд ээжтэйгээ хамт очно... Тэдгээр өдрүүдэд л бүтэн нойртой хонож, сэтгэл маань жоохон амсхийнэ. Гэвч өдөр хоног өнгөрч буцаад л хэвийн амьдрал минь намайг угтана.

Аавын минь араатан шиг зан авир өнгөрсөн сэтгэлийн шархууд дээр минь өдөр бүрээр нэмэрлэсээр зүрх сэтгэлд минь гүн гүнзгий шарх үүсгэсэн. Энэ бүхэн хэзээ дуусах нь мэдэгдэхгүй үргэлжилсээр, нүд минь нулимсаар дүүрэн, сэтгэл минь гунигт бодлуудаар дүүрэн өдрүүд яг л түүдэг утас шиг хөвөрч байсан.

Сул дорой, хүчгүй, эрх мэдэлгүй хүүхдүүд бидний хамгийн ойрын туслагч, хамгаалагч, хайрыг мэдрүүлэгч, хангагч, өмгөөлөгч нь байх үүрэг эцэг эхчүүдэд өгөгдсөн шүү дээ. Гэвч энэ бүхнийг авах хэрэгцээтэй хүүхдүүд танихгүй хүнээс бус хамгийн ойрын хайртай хүнээсээ доромжлол, зодуур, айдас дарамт, хүчирхийлэл харгислалыг мэдрэх нь дэндүү шударга бус, аймшигтай.

Миний хувьд аав хэмээх хүний халуун дулаан ханхар цээж, аавын цамцнаас үнэртэх үнэр, дулаан тэврэлт, харц, сайхан дурсамжууд зүрх сэтгэлийн минь орон зайн хаана нь ч үлдээгүй.

Одоогоос нилээн хэдэн жилийн өмнө аав маань архинд живж, өвлийн нэгэн хүйтэн өдөр гэртээ ирж амжилгүй нас барсан юм. Энэ эмгэнэлтэй мэдээ биднийг цочирдуулсан. Үүнээс хойш ээж минь хэдэн хүүхдээ "өрх толгойлсон эмэгтэй" гэдэг нэрийн дор өсгөж, биднийгээ боловсролтой, мэргэжилтэй хүн болгохыг зорьсоор ирсэн.

Бид хүчирхийлэл дор өссөн хүүхдүүд заавал хүчирхийлэл үйлдэгч болдоггүйг өөрсдийн биеэрээ үлгэрлэн харуулахыг зорьж, харин ч хүчирхийллийг үл тэвчдэг хүн болохоор "Нийгмийн ажилтан" мэргэжлийг эзэмшсэн. Хүчирхийллийн сүүдэр хүүхдэд хэрхэн нөлөөлдгийг өөрийн биеэрээ мэдэрч өссөн хүний хувьд ийм байдалд байгаа хүмүүст туслахаар төрийн бус байгууллагыг байгуулан сэтгэл шулуудан ажиллаж байна.

Миний туулсан амьдралын бараан өдрүүдийг дахин нэг ч болтугай хүүхэд бүү мэдрээсэй гэсэндээ хүүхэд, эмэгтэйчүүд рүү чиглэсэн олон ажлуудыг санаачлан хэрэгжүүлж эхлээд байгаа.

Эргэн тойронд тань тааралдах гашуун нулимстай, харанхуй бараан өдрүүдийг туулан өнгөрүүлж байгаа хүүхэд эмэгтэйчүүдэд таны тусламж маш их хэрэгтэй байдаг юм шүү.

Хүчирхийллийн эсрэг таны хийх алхам бүр хүчирхийлэлд өртсөн хэн нэгний амьдралд хонгилын үзүүрт асах гэрэл адил итгэл найдвар, урам зоригийг өгч байдаг.

Бусдын төлөө хийсэн таны багахан тус тэдний ирээдүйн амьдралд төсөөлшгүй өөрчлөлтийг авчирч чадна гэдэгт итгээрэй.



БҮХ ЗҮЙЛ ӨӨРЧЛӨГДӨХ БОЛОМЖТОЙ...

Зүрх сэтгэлийн минь нэгэн тал болсон амьдралынхаа ханьтай учрах нууцхан мөрөөдөлтэй явсан надтай нэг л өдөр түшиг тулга, хайр энхрийллээ мэдрүүлсэн нэгэн сайхан залуу учирсан юм. Түүний амлалт, халуун дулаан үгс нь зүүд шиг амьдралыг надад бэлэглэх юм шиг санагдаж билээ. Намрын сайхан өдөр хурим найраа хийцгээж өрх гэрээ тусгаарлалаа. Амьдран суугаад төд удалгүй нөхөр маань архи дарстай нөхөрлөх нь элбэгшиж эхлэв. Анхны амлалт үгсээсээ тэс өөр хүн болон хувирч байгаа түүнийг харахдаа би их л гайхширдаг байлаа. Эдгээр үйл явдлууд зүүдэнд ч оромгүй, хэзээ ч төсөөлшгүй хатуу амьдралын минь эхлэл байсныг би яахан мэдэх билээ.

Хөөрхөн алаг үртэй болчихоод төлөвшиж тогтох болов уу? гэж горьдсон ч итгэл найдварыг минь хээрийн цэцэг шиг гишигчин тасдаж б-хан сартай нялх үрээ энгэртээ эрхлүүлэн байхад минь хайр гамгүй зодон, өвлийн хүйтэн шөнө хөөн явуулж байсан.

Хүүхдээ тэврээд гэрээсээ хөөгдсөн би аргагүйн эрхэнд өөрийн төрсөн эгчийндээ хэсэг хугацаанд толгой хоргодохоор очсон юм. Нэг өдөр эгчийн байрны ойролцоох цэцэрлэгийн сааданд хүүхдээ салхилуулж байтал хаанаас ч юм бүү мэд гэнэт нөхөр маань гарч ирээд охиноо бодъя, би дахиж чамайг зодохгүй, би өөрчлөгдөх болно гэж амлаж, байнга л гуйх болов.

Энэ үед үнэхээр амлалтандаа хүрээд өөрчлөгдөх болов уу гэсэн итгэл найдвар төрж, зүрхэнд минь уучлал буусан юм. Өдөр бүр шалдаа буун гуйх түүнийг хараад өрөвч зөөлөн чанар минь дотроос ятгаж дахин нэг амьдраад үзэхээр шийдсэн.

Үүнээс хойш бурхнаас бэлэг болгон дахин хоёр хүүхдийг минь илгээсэн. Хүүхдээ тээж төрүүлэх бүртээ нөхөр маань хүүхдүүдээ хараад өөрчлөгдөх болов уу, үүргээ мэдэрч хариуцлагаа ухамсарлах болов уу гэсэн бяцхан хүлээлт маань өдөр ирэх тусам замхарсаар байлаа. Уучилж эргэн нийлсэн шийдвэрийнхээ төлөө харамсан гашуудах өдрүүд угтсаар байсан юм.

Ингэж цаг хугацаа хөвөрсөөр хүүхдүүд томорч ажил хийх боломж бүрдэж билээ. Гэвч ажлын газарт ирж хэл амаар доромжилж, хардаж, бүр ажил дээр гар хүрч ажиллах нөхцөл бололцоог минь үргэлж хаанбоогдуулж байсан юм. Энэ бүх байдал эцэс төгсгөлгүй айдас дарамт зодуур нэг л өдөр миний тэвчээрийг барж бүрсгэр харанхуй хүчирхийллийн тойрогт орсноо ойлгож, тэрхүү тойрогтоо эргэлдсээр байгаа өөрийгөө олж харсан юм. Мөн нэгэнт нөхөр маань гаргаж буй үйлдлээ зогсоох нь битгий хэл, ухамсарлаж ойлгох, буруугаа хүлээн зөвшөөрөх чадваргүй болохыг олж

харсан минь юу юунаас илүү их ололт байсан. Үүнийг ухаартлаа хэр их зовсноо хараад гайхдаг үе надад бий. Энэ бүхнээс үндэслэн энэ амьдралаа өөрчлөхөөр шийдэж гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд хандлаа.

Миний шүүхэд хандсан явдал өнөөгийн хууль хэрэгжүүлэгчдийн хандлага, үйлчилгээ ямар байгааг харуулсан юм. Эхний удаад биднийг эвлэрүүлэн зуучлалаар оруулсан нь хугацаа алдаж хүчирхийлэл үргэлжлэх боломжийг олгосон. Тухайн үед өмссөн хувцастайгаа 2 хүүхдээ чирээд гэрээсээ хөөгдсөн миний хувьд Улсын тэмдэгтийн хураамжийг төлөх чадваргүй учраас хорооноос амьжиргааны түвшний тодорхойлолт авах гэсэн боловч "Үнэлгээ хийх болоогүй байна, та нөхөртэйгээ хамт амьдарч байхдаа боломжийн байжээ" гэснээр улсын тэмдэгтийн хураамжийг төлөхөөс өөр аргагүй болж мөнгө олох гэж бас л хугацаа алдсан. Энэ бүхнийг зохицуулан арай гэж нэхэмжлэлээ өгтөл нөхөр чинь хаяг дээрээ алга гэсний дагуу эрэн сурвалжлуулах хүсэлт гаргасан. Энэхүү олон шат дамжлагын улмаас бидний гэрлэлтээ салгах хугацаа хойшилсоор байлаа. Мөн нөхөр чинь олдохгүй байна, алга болчихлоо, шүүх дуудаад ирэхгүй байна гэх зэрэг шалтгаануудыг хэлж та өөрөө олоод өгөөч гэсний дагуу өөрийн амийг эрсдэлд оруулан байж, удаа дараа түүнийг олж өгч билээ. Энэ бүх процесс үйл явцын дараа гэрлэлтээ цуцлуулсан боловч бага хоёр хүүхдийн минь тэтгэлэг төлөгдөхгүй бас л хохирсоор явна.

Иргэдээ хамгаалахад чиглэсэн хуулийн байгууллагын үйлчилгээ хохирсон дээр нь улам хохироож байгаагийн тод жишээ нь би болсон. Энэ бол ганцхан миний амьдралын түүх хэдий ч надтай адил замналтай олон эмэгтэйчүүд ийм байдлаар асуудлаа шийдүүлэхдээ эрхээ хамгаалуулж чадахгүй шантарч, эрсдэлд орж эсвэл амиа алдаж байна.

Миний хувьд хүүхдүүдээ айдасгүй тайван орчинд өсгөх болсондоо баярлаж, ирээдүйгээ өөдрөгөөр харж, урдаа тавьсан зорилгодоо хүрэхийн төлөө хичээж явна.

Хүчирхийллийг зогсоохоор шийдэж, үүнээс өөр сайхан амьдрал байдаг, би үүнийг хүртэх эрхтэй, би хүчирхийлэлд байх ёсгүй гэж итгэх үед бүх зүйл өөрчлөгдөх боломжтойг ухаарсан.

Хүн бүр хайрлах, хайрлуулах эрхтэй. Хүчээр айлган сүрдүүлж, бие махбод, сэтгэл зүрхийг минь шархлуулах эрх хэнд ч байхгүй. Бид нар өөрсдөө зөвшөөрөөгүй цагт энэ бүхэн өөрчлөгдөх боломжтойг өөрийн биеэрээ туулж мэдэрч ойлгосон эгэл жирийн эмэгтэй байна. Надтай адил нөхцөлд, хий хоосон итгэл найдвар тээн, чамайг хэзээ ч хайрлахгүй тэдгээр хүмүүсийн хүчирхийллийн хүлээснээс чөлөөлөгдөөсэй гэж хүсч байна. Та ингэж амьдрахаар энэ дэлхийд төрөөгүй юм шүү гэдгийг захъя. Хүн бүр үнэ цэнэтэй. Түүнийгээ үргэлж мэдэрч амьдрах нь амьдралын утга учир юм. Та бүхэн минь над шиг битгий оройтож ойлгоосой.



ААВААСАА АЙГААД ХҮҮХДҮҮД АВТОМАТААР БОСООД ЗОГСЧИХДОГ БАЙСАН...

Миний бие төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжихийн өмнө буюу 1986 онд нөхөртэйгээ танилцаж 2 сайхан хүүхдээ төрүүлж 1990 онд албан ёсоор гэр бүл болж билээ. Тухайн үед би худалдагчийн курс төгсөн худалдагчаар ажиллаж байлаа. Гэр маань холдоод байсан тул хэсэг хугацаанд ажлаасаа гарч дахин нэг хүүгээ төрүүлсэн юм. Ам бүлийн тоо нэмэгдэж ажилгүй болсон тул нөхөр маань байшингаа хүнд түрээслүүлэхээр шийдэж эгч дүү хоёр эмэгтэйг суулгасан тэр цаг үеэс л хүнд хэцүү амьдралын минь эхлэл тавигдаж билээ.

Учир нь нөхөр маань нэг хашаанд 2 эхнэртэй амьдрах болсон. Намайг байнга гоочилж, өдөр бүр зодож, шөнө нүцгэн биеэр минь гэрээсээ хөөж гаргадаг болсон. Би шөнөжин гадаа чичирч хонодог байсан бөгөөд хүүхдүүдийг минь хаалгаа тайлвал алнашүүгэжсүрдүүлэхболсон. Хөлдөж үхэхгүйн эрхэнд айлаас хувцас гуйж сүүлдээ орой ирэхээс нь өмнө гадаа хувцсаа нууж тавьдаг болсон. Олон ч удаа хүүхдүүдтэйгээ гэрээсээ хөөгдөж ахындаа мөн эгчийндээ очиж хонох бүрт араас ирж цонхыг нь хага цохиж, хаалгыг нь эвдэлснээс болж сүүлдээ биднийг оруулахаа больсон. Аргагүй ч

биз дээ тус тусын амьдралтай хүмүүс шүү дээ.

Энэ бүх байдлаас болж салах тухай хэлэхэд надаас салбал ална, эсвэл тахир дутуу болгоно гэх зэргээр доромжлох нь энүүхэнд болов. Нөхрийн сүрдүүлэг, дарамтаас болж хаашаа ч зугтаад нүүж очсон яаж ийгээд л араас олж ирээд хүйтэн мэсээр далайлган гэр лүүгээ авч явдаг байсан.

Бид 1993 онд хадам аав ээжийг бараадан Хэнтий аймагт хөдөө мал дээр нүүж очоод удаагүй байтал нөхөр маань мөрийтэй тоглоомонд дурлан олон хоногоор гэртээ ирэхгүй удах тохиолдол их болов. Энэ бүхнийг ээж аав нь харсан ч хүүдээ хир халдаадаггүй.

1994 оны өвөл нөхөр маань цагаан сарын бэлтгэл хийхээр нь яваад ирэхгүй удсаар тухайн жилийнхээ 4-н сард бие муудлаа ир гэснээр удахгүй төрөх дөхсөн байсан ч саалийн 5-н үнээтэйгээ хот руу нүүж ирсэн. Биеийг нь асран тэнхрүүлж, үнээгээ саагаад сүүг нь заруулахаар нөхөртөө өгөөд явуулдаг ч орой нь сүү ч үгүй, мөнгө ч үгүй ирдэг. Мөнгө л олдвол мөрийтэй тоглоом тоглож, ар гэртээ хоол ундтай байна уу, хэн нь өвдөж зовж байгаа бол гэж хайхрахаа ч больсон. Би бага насны 4 хүүхэдтэй, зах дээр хуушуур

зарж гэрийнхээ хоолыг залгуулж байв. Аавыгаа өнгөрөхөд буяны ажилд нь очих зардлын мөнгөгүйдэмийлгэртээ шаналан, гашуун нулимсаа урсган, дутагдаж гачигдаж буй амьдралдаа гомдон өнгөрүүлж байсан үе үнэхээр хэцүү байсан даа.

Үргэлж л өөр эмэгтэйчүүдтэй нэр холбогдон, завхай байдал нь ил болсон ч илчлэгдэх үед түүнийгээ хаацайлах, буруутай ичгэвтэр үйлдлээ далдлахын тулд хүчирхийлэл нь дээд цэгтээ хүрдэг.

Тэр хүнд хайртай халамжлах гэсэн сэтгэл бус айх айдас маань намайг аргамжин түүнтэй хамт байлгаж байсан. Энэ бүх хүчирхийллийн нөлөөнд хүүхдүүд маань үргэлж нүд нь бүлтэгнэж, аавыгаа согтуу ирж байгааг хараад айхдаа автоматаар босоод зогсдог болсон байв.

Би олон удаагийн зодуур бэртлээс болж аарцаг яс гэмтэж, тархины цусан хангамжийн дутагдлаас шалтгаалж ухаан алдаж унадаг болсон. Яг энэ үед нөхөр маань архидаж байгаад хүн амины хэргээр 20 жилийн ял авсан юм.

Би 0-18 насны зургаан хүүхэдтэй үлдэж тэднийхээ төлөө нэгчөдөр урам хугарч байгаагүй, уйгагүй ажиллаж хөдөлмөрлөж байлаа. Миний хичээл зүтгэлийн ачаар гурван охин минь их дээд сургуулиа амжилттай төгссөн. Хоёр хүүхэд маань мэргэжлийн коллеж төгссөн. Одоо бага хүү маань 10 жилийн сургуульд амжилттай суралцаж байна. Хүүхдүүд маань тус тусынхаа замаар гадаад, дотоодод үнэхээр сайхан амьдарч байна.

Бид 2005-2017 оны хооронд их хөдөлмөрлөж өөрсдийн хашаа байшин, байр орон сууцтай болсон. Хүүхдүүдийн минь хичээл зүтгэл надад маш их дэм болсон. Би энэ хооронд ямар ч ажлыг голж байгаагүй, олдсон ажлыг урам зоригтойгоор хийсэн. Мөн хажуугаар нь хадам ээжийг хүртэл харж хандана. Ингээд 12 жил би ямар нэгэн хүчирхийлэл дарамтгүй өөрийнхөөрөө амьдарсан. Гэтэл 2017 онд нөхөр суллагдаж гарч ирснээсээ хойш хүчирхийлэлтэй харилцаа үргэлжлэх болж амь насанд ноцтой аюул заналхийлэх болсон.

Ингээд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандаж мэргэжлийн туслалцаа үйлчилгээ авснаар хүчирхийлэлтэй харилцаандаа цэг тавьж чадсан. Олон жилийн хүчирхийлэл дарамт, аюултай нөхцөл миний залуу насны олон сайхан мөрөөдөл, хүсэл эрмэлзэл, аз жаргалыг минь үгүй хийсэн. Гэхдээ үүнийг зогсооход оройтоно гэж хэзээ ч байдаггүйг ойлгосон. Харин үр хүүхдийн минь амар тайван, аюулгүй байдал, өөрийн минь амь нас эрүүл мэнд хүчирхийллийн золиос болоход оройтсон үе гэж байх юм билээ. Залуу насны минь сайхан үе нөхөж үл олдох ч үлдсэн цаг хугацаанд аз жаргалтай амьдрах боломж бий гэж итгэж байна. Одоо би тэтгэвэрт гарсан. Сэтгэл амар ач, зээгээ харан сууна.



НАДАД МӨРӨӨДӨЛ БАЙСАН...

Цэцэг цэврүү шиг дэрвэлзэн, өнгө өнгийн гоёмсог хувцсаар гангарч хээрийн цэцэгсээс илүү анхилам бөгөөд танхил явсан бага нас минь саяхан. Гэнэн цагаахан сэтгэл, хүсэл мөрөөдлөөр дүүрэн бодлууд, чин зүрхний минь инээмсэглэл, толбогүй өдрүүдээр амьдрал минь үргэлжилсээр.

Бусдаас дутуугүй л амьдарч байлаа. Аав маань ухаан орох цагаас л миний дэргэд байсан учир өөрийн төрсөн аав шигээ л бодож, намайг хоёр дүүгээс минь ялгаагүй хайрлаж, дутагдах зүйлгүйгээр өсгөсөн. Ирээдүйд цагаан халад өмссөн эмч болж олон хүнд туслана даа гэсэн мөрөөдлөөр хичээл номдоо шамдсан сурлагадаа сайн охин байлаа. Аав зах дээр мужаан хийж, ах түүнийг аваачиж борлуулдаг байсан юм.

Би дөнгөж 9-н настай байлаа. Ээж маань дүүг тээж байгаад тэр нэгэн шөнө өвдөлт өгч эмнэлэгт хүргэгдсэн юм. Айдас төрүүлэм тэр шөнө аав маань намайг хүчиндсэн. Айх гайхах, өвдөх, уйлах зэрэгцсэн тэр шөнө надад аавууд угаасаа хүүхдүүдээ

ингэж хайрладаг юм, энэ нь хэвийн үзэгдэл учраас хүнд хэлж болохгүй гэж хатуу сануулж билээ. Түүнээс хойш аавын надад хандах байдал эрс өөрчлөгдөж илүү их хяналтандаа байлгаж, анхаарах болов.

Ямар нэгэн байдлаар хоёулханаа үлдэх далим гарган оролдож, хүчиндсэнийхээ дараа гадуур дагуулан явж, хүссэн зүйлсийг минь худалдан авч өгдөг байлаа. Яагаад ингэж аашлаад байгааг ойлгох нас, ухаан маань даанч хүрдэггүй байлаа. Ааваасаа айн намайг хайрлаж өссөн ээжээсээ хүртэл энэ бүхнээ нуун уйлж байсан өдрүүд олон байсан. Сэтгэл зүйн байдлын хувьд үргэлж тогтворгүй. Нэг болохоор уйлмаар, хэнтэй ч дуугармааргүй эсвэл бүхнээ хэлмээр өдрүүд үргэлжилж байлаа. Хичээлдээ ч дургүй болсон. Ээж минь энэ байдлыг маань ерөөсөө анзаардаггүй байсан.

Ингээд нэг мэдэхэд жирэмсэн болсноо ч мэдэхгүй арван дөрөвхөн насандаа анхны хүүхдээ төрүүлсэн юм. Ойр тойрныхон бүгд гайхацгааж байсан боловч энэ учрыг нь тайлах ганц

хүн аав минь байсан. Тухайн үед нэг бандитай найзалж байгаад жирэмсэн болчихжээ гэдгээр бусдаас хаацайлан өнгөрсөн. Хоёр нүүртэй, худалч дүр исгэсэн аавыгаа харахаар заримдаа үнэхээр аймшигтай санагддаг байлаа. Хүчгүй сул дорой, өөрийгөө хамгаалах чадваргүй надад хандаж байсан түүний бэлгийн гаж хүсэл нь түүнийг насан туршид нь шоронд хорьж болох байсныг би яахан мэдэх билээ.


Хүүхэдтэй болсноос хойш аавын хараа хяналт улам бүр нэмэгдэж, үе тэнгийхэнтэйгээ уулзахыг минь хориглож хардах болов. Нэгэн өдөр би ээжтэй үл ойлголцол үүсэхдээ бухимдаж бачимдсан сэтгэлээрээ болсон бүхнийг хэлсэн юм. Тухайн үед ээжид минь хүнд цохилт болж харгис балмад хатуу сэтгэлтэй аймшигтай нөхөртөө итгэж ядан энэ бүхнийг шийдүүлэхээр холбогдох газруудыг судалснаар Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандсан юм. Ийнхүү болсон бүх хэрэг шалгагдаж аавд 23-н жилийн ял оногдуулснаар ичгэвэртэй бөгөөд аймшигт хар дарсан зүүд шиг амьдралын минь бараан өдрүүд дууссан юм.

Амьдралын гол ачааг үүрч байсан аав шоронд явж бидний амьдралын түвшин өөрчлөгдөж, ээж маань сэтгэл зүйн хувьд хүнд байдалд байсан ч эд материалаас илүү айх аюулгүй, амар тайван амьдрал хүнд ямар чухал болохыг бид ойлгосон доо.

Өнгөрсөн амьдрал минь бусад хүүхдүүдийн адил гэнэн цагаахан, айдасгүй, амар тайван өнгөрөөгүй ч энэ бүхнийг ээжийнхээ хамтаар мөн хүчирхийллийн эсрэг зүрх сэтгэл нь цохилж, хөдөлмөрлөн байгаа олон сайхан хүмүүсийн ач тусаар даван туулаад 12 жилийг ардаа үджээ.

Эмч болно доо хэмээн мөрөөдөж байсан, өөр бас олон сайхан дурсамж бүтээх хүсэл минь биелээгүй ч өдгөө би тангараг өргөсөн төрийн тусгай албан хаагч болж, сайхан ханьтай 4-н сайхан хүүхдийн ээж болон бусдын адилаар ажиллаж хөдөлмөрлөж, айх айдасгүй амар тайван амьдарч байна.

Гэхдээ л надад мөрөөдөл байсан...





АНИРГҮЙ ЕРТӨНЦИЙН ГЭГЭЭ

Хөдөөгийн алсхан нэгэн сумын жавар хургасан ядруухан айлд хоёр охин зулай зулайгаа гишгэн мэндэлсэн юм. Миний хувьд тэр айлын ууган охин болсон ч хүний орчлонд хувь дутаж би сонсголгүй төрсөн байлаа. Надад бэлэг болон ханьсах гэж ирсэн ганц дүү минь ч надтай адил сонсголгүй төрсөн.

Аав минь харааны бэрхшээлтэй байснаас гадна биднийг сургуульд орохын өмнөхөн ээж минь өвчний улмаас хорвоог орхилоо. Ингээд амьдрахын эрхээр хот руу нүүж ирж бор хоногийг зутруухан өнгөрүүлсэн амьдрал минь эхэлсэн. Биднийг амьшигээ хайрлаж байсан ээжийг үгүй болоход аав минь группийн мөнгөөрөө амьдарч дийлэхгүйд хүрч аргагүйн эрхэнд дүү бид хоёрыг 29-р тусгай сургуульд бүртгүүлж, дотуур байранд оруулсан. Тухайн үед аав минь бид хоёрыг байрны тогооч эгчид харж хандаж байхыг захиж үлдээсэн юм.

Бид сургуульдаа явж хичээл, номондоо шамдан цаг хугацаа ч харвасан сум шиг өнгөрсөн. Тогооч эгч бидний ээж шиг л дотно байсан. Ангийн багш маань надад их л сайн хандаж, үе үе гэрийн ажил болон өөртөө туслуулдаг болсоор нилээдгүй хугацаа өнгөрлөө. Энэ хүний сайхан сэтгэлд үргэлж талархдаг байлаа. Би яг л тэдний гэр бүлийн гишүүний нэг болж асуудал

бэрхшээл бүрийг нь мэддэг болсон юм. Багшийн маань нэг хүү нь оюуны хомсдолтой, сонсголын бэрхшээлтэй надаас олон насаар ах хүн байлаа. Тун удалгүй багш хүүтэйгээ суулгахаар намайг ятгаж, уурлаж нэг үзнэ бас аргадаж нэг үзнэ. Гэвч миний хувьд сургуулиа төгсөх нь чухал байсан болохоор хүнтэй суух тухай огтхон ч бодож байгаагүй юм. Хүндэлж талархаж байсан багш минь нэг л өдөр санасандаа хүрч бичиг баримтыг минь авч хүүтэйгээ гэрлэлт бүртгүүлэн тухайн үед улсаас өгч байсан залуу гэр бүлийг дэмжих 500.000 төгрөгийг авсан байлаа.

Сургуулиа төгсөхтэй зэрэгцээд дотуур байрнаас гарах ч боллоо. Бид хоёр ааваасаа сураг тасарч хаана амь зуун амьдарч байгааг мэдэхээ болив. Багш энэ сиймхийг ашиглан гэртээ амьдрахыг санал болгосноор өөр очих газаргүй тул гэрт нь очлоо. Төд удалгүй хүү бид хоёрынх нь харилцаан дундаас хөөрхөн охин минь төрсөн юм.

Багш ачтай болсондоо баярлаж байгаа ч ааш зан нь бага багаар өөрчлөгдөж, уурлаж бухимдахаараа хүүхдээ орхиод яв гэж хөөж туух нь ихэссэн. Хүү нь ч гэсэн үе үе гар хүрдэг ч надад хэлэх хүн байхгүй учир тэвчихээс өөр аргагүй байлаа. Ингэсээр охиныг минь авч үлдээд намайг орох оронгүй гэдгээр

гудамжинд, өвлийн хүйтэнд хөөж гаргасан. Бүх зүйл хэрээс хэтэрсэн тул нөгөө тогооч эгчдээ хэлээд дүүгийнхээ хамт Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандан зөвлөгөө авахаар зориг гарган очсон юм. Тэнд очихдоо дүү бид 2 биднийг ойлгох болов уу? надтай харилцаж чадах болов уу? гэсэн итгэл муутайхан хаалгаар нь орсон ч биднийг уриалагхан тосч авсан эмэгтэй маань дохионы хэлээр маш чадварлаг харилцаж байсанд чухам л бүх асуудлаа шийдвэрлүүлчихсэн мэт сэтгэлд минь итгэлийн оч үсэрсэн юм. Ингээд хамгаалах байранд байрлан үйлчилгээ авч, эмэгтэйчүүдийг чадавхжуулах дэмжих бүлэгт нь тогтмол хамрагдаж, өөртөө итгэлтэй болж тэдний эсрэг шүүхэд зориглон хандсан. Охиноо өөрийн асрамжинд авч, 24 цагийн цэцэрлэгт өгч, өөрөө ажил хийн группийн мөнгө, ажлын хөлс зэргээрээ байшин түрээсэлж тайван амьдрах болсон юм.

Шүүхээр гэрлэлтээ цуцлуулж, хүүхдийн асрамжийн асуудлаа шийдүүлсэн ч нөхрийн талынхан хүүхдийг минь авах гэж намайг их зовоосон. Энэ бүхнийг даван туулж амьдралаа өөрчилж чадсандаа баяртай байна. Хэдийгээр миний асуудал шийдэгдсэн ч чимээгүй байдал дотор үнэн нь илчлэгдээгүй хүчирхийллүүд байсаар байна.

Манай сургуулийн орчинд сурагч охидуудад ийм асуудал их тохиолддог ч бэрхшээлээсээ болоод хаана, хэнд, яаж хандахаа мэддэггүй. Бидний төрөлх хэл нь дохионы хэл. Үйлчилгээ авах болон өдөр тутмын амьдралд дохионы хэлмэрч шаардлагатай болдог. Хууль шүүхийн байгууллагаар асуудлаа шийдүүлэхэд хэлмэрч хэрэгтэй байдаг ч цагийн хөлс нь өндөр тул авах боломжгүй байдаг.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие биенээ маш сайн мэддэг тул нууц амархан задардаг. Хичнээн нууцлал хадгалах талаар сануулсан ч хэлмэрчид итгэхэд бэрх санагдана.

Тэргэнцэртэй болон харааны бэрхшээлтэй хүн улсын түвшинд өөрөө бие даан үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал байдаг тул хүчирхийлэл үйлддэг асран хамгаалагч, харзалзан дэмжигчийнхээ хамт үйлчилгээ авах болно. Ийм тохиолдолд асуудлыг ил гаргана гэж үү? Эдгээр нь бидний хувьд хана хаалт болсоор байна. Хүчирхийлэлд өртсөн олон хүүхэд эмэгтэйчүүдийг ухрахад хүргэдэг, зоригийг нь мохоодог эдгээр шалтгаанууд хүчирхийлэлтэй орчин руу нь буцаад түлхэн оруулж, бүхнийг тэвчин өнгөрүүлэхээс өөр аргагүйд хүргэдэг.

Иймд хөгжлийн бэрхшээлийнх нь онцлогт тохирсон байдлаар гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах боломжтой талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан мэдээлэх, хууль зүйн тусламж үйлчилгээ авахад эрх тэгш боломжоор хангах нь чухал байна.

Хэдийгээр би сонсголын бэрхшээлтэй, гэр бүлийн минь амьдрал хүнд байсан ч хүчирхийлэлд бууж өгөөгүй, зориглон амьдралаа өөрчлөхөөр шийдсэн. Одоо бодоход бэрхшээл маань намайг улам хатуужуулж, бусдын эрхшээлд хүч чадалгүй сул дорой амьдрах утгагүй болохыг ойлгуулсан. Тиймээс би зорилготой амьдарч, бууж өгөхгүй байхаар шийдэж хичээнгүй зүтгэсний үр дүнд одоо орох оронтой, охинтойгоо, дүүгийнхээ хамт амар тайван амьдарч байна.

ГЭР БҮЛИЙНХЭЭ АСУУДЛЫГ ИЛ ГАРГАХЫГ ЗОРИГЛООГҮЙ

Надад юм бүхэн байсан. Гэрэл гэгээ цацруулсан харц, баяр баяслыг урин дуудсан инээд, үл холдох залуу нас, ирээдүйгээ цав цагаахнаар төсөөлсөн мөрөөдлүүд байсан. Энхмөнхийн гэргий хэмээгдэх болсноос хойш цагаан бүхэн минь саарал, бүр сүүлдээ тас харанхуй болж хувирсан. Би бусдаас дутахааргүй ажилтай нэгэн байв. Залуу нас хайр сэтгэл хоёр ихэр байдаг учир айлын эхнэр, хүний гэргий болсон нь 2003 он.

Аз жаргал, амьдралын нэг хэсгээ оллоо хэмээн бодсон тэр өдөр ирээдүйд намайг том ангал нүх хүлээж байсныг би яахан мэдэх билээ. Хэрвээ өнгөрснийг буцааж чаддагсан бол түүний гэргий гэгдэх болсон тэр өдрийг эхлүүлэхгүй байсан даа гэж харамсдаг.

Гэрлэлтийн эхний жил хардалт хэмээх хар манангийн сүүдрээр цоожтой гэрт хуруун чинээ хүүгээ тэврэн уйлж суусан нь олон. Торон цонхтой цоожтой хаалганы цаана би дөрвөн жил суусан. Өглөө ажилдаа явахдаа түгжинэ. Орой л ирж онгойлгоно. Хүүхдүүдээ өсгөх нь аз жаргал байдаг ч нөхрийн доромжлол, зодуур, гаж үйлдлийн боол болж амьдарсан гэхээр ухамсарт нэгний ой тоонд буухгүй л байх.

Өдөр бүр л нөхрийнхөө ааш авирыг засрах байх, хүүхэдтэй болохоор өөрчлөгдөнө гэж итгэж найдна. Манай гэр бүл бусдын нүдэнд дутах зүйлгүй сайхан айл. Халамжтай хань, сайн аав, амьдралаа авч яваа эр хүн. Гэвч тэр дөрвөлжин байшин доторх амьдрал ганцхан хүний харцан дор үргэлжилнэ. Би гэр бүлийнхээ асуудлыг бусдад ил гаргахыг зориглоогүй, эр нөхрийнхөө муу муухайг олонд дэлгэхийг хүсээгүй. Энэ дарамтаа бусдаас тас нууж, зүрхэндээ нулимстай амьдарсан. Зулай зулайгаа гишгэн төрсөн хүүхдүүд минь цэцэрлэг, сургуульд орохтой зэрэгцээд нөхрийнхөө ажилд дэм болж, гэрээр юм оёж, зарж борлуулдаг болов.

Би элэг бүтэн амьдралын төлөө өөрийн биеэ хайрлаагүй, гаргуунд хаясан. Нөхрийг ажлаас ирэхэд халуун хоол цайтай л угтахгүй бол “Өдөржингөө хэнтэйгээ ноололдоод аяга юм хийдэггүй янхан вэ” гэж хамаг юмаа хагачиж, шидлэх тоолонд жижиг өрөөнийхөө хаалгыг хамаг тавилгаараа хааж, хэдэн хүүхэдтэйгээ бүлтэгнэж суусан шөнө надад олон бий. Амь биш заяа биш хэмээн зориг гаргаж хотод байдаг ээж рүүгээ явахаар вагонд суутал нөхөр газрын хаанаас намайг явах гэж байгааг мэдсэн юм

бүү мэд хүрч ирээд чирсээр буулгаж, “надаас салснаас үхсэн нь дээр” гэж вагон доогуур хийхээр чирч байсныг хавь ойрын хүмүүс арай гэж салгаж байсан.

Би гэдэг хүн ирээдүйгээ нэг ч удаа гэгээнээр харахаа больж өлбийсөн нэгэн болсноо ч анзаараагүй. Энэ их дарамтыг хүүхдүүдээ эцэгтэй нь байлгая, гэр бүлийнхээ нэр хүндийг хамгаалъя гэж тэвчсээр байсан... Гэтэл миний энэ харалган бодлоос ид цэцэглэж байсан охин минь аль хэдийн тасдуулаад хагдарсан цэцэг болсныг хожуу олж мэдэв. Ээжийнхээ зовлонт амьдралд нэрмээс болохгүй гэж хойд эцгийнхээ бэлгийн хүчирхийлэл дор охин минь 5 жил тарчилж. Эх хүн учраас тэсэх л ёстой хэмээн өөртөө тулгасан он жил намайг төдийгүй охиныг минь тамд унагасан байлаа. Дэндүү хайхрамжгүй явж дээ. Даанч хааяа охинтой минь утсаар ярихдаа биений юм нь ирэх болж байна уу, найз бандитай болоо юу зэргээр хот руу сургуульд явсан хойгуур ярьж асуудаг байсныг анзаардаггүй ч байж.

Энэ бүхнийг хэрээс хэтэрснийг ойлгож өөрийнхөө гараар бүтээсэн энэ амьдралдаа цэг тавихаар шийдэж мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг байгуулагад хандаж, гэрлэлтээ салгуулж, охины хэргээр хууль шүүхийн байгууллагад хандсанаар нөхөрт холбогдох хариуцлагыг хүлээлгэсэн.

Хий хоосон дүр эсгэж, эр нөхрийнхөө нэр төрийн төлөө олон үнэт зүйлсээ алдаж байсандаа их л харамссандаа.

Өнгөрсөн он жилүүдэд яагаад ийм шийдвэр, ийм зориг гаргаж чадаагүй юм бэ, гэж өөрөөсөө олон удаа асуусан. Нэг л удаа зоригтой алхам хийсэн бол миний охины нүүрэнд айдас, гуниг бус, яг л ээжийнхээ залуу насны эхлэл шиг инээд хургаж байх байсан.

Гэвч өнөөдөр би хүүхдүүдтэйгээ айдасгүй, ирээдүйг гэгээнээр төсөөлөн, сэтгэл тайван амьдарч байна. Хайрыг хайр гэж харахгүй дэлгэсэн зүрх, гаргасан сэтгэл дээр минь дураараа туучиж байсан тэр хүнийг би өөрчилж чадахгүйгээ ухаарсан.



ТЭМЦЭЛ ХЭЗЭЭ Ч ОРОЙТОХГҮЙ

Манайх Дархан хотод амьдардаг байлаа. Би айлын долоон хүүхдийн хоёр дахь нь болж мэндэлсэн. Миний бага нас архины хамааралтай аавынхаа хүчирхийлэл дарамт, айдас дунд өссөн. Ээжийгээ хамгаалан олон ч шөнө бид нуугдаж, зугтаж өнгөрүүлсэн дээ. Тэр нэгэн өдөр Монгол улсын хамгийн сайн циркийн сургуульд суралцагч шалгаруулж авах зарыг харсан юм. Энэ тухайгаа гэрийхэндээ хэлэхэд аав маань намайг дагуулж Улаанбаатар хотод ирж шалгаруулалтад оролцуулсан. Ингээд 550 хүүхэд оролцсноос хоёр хүүхэд шалгаруулж авахад азтай тохиолдлоор би тэнцсэн юм.

Суралцаж байх хугацаандаа нагац эгчийндээ амьдардаг байлаа. Надтай яг л боол зарц шиг их л дээрэлхүү хандана. Эцэс төгсгөлгүй дарамт, хүнд хэцүү бэрхшээлийг дуусгах гарц нь сургуулиа амжилттай суралцаж төгсөх гэж бодсон учир бүхнийг тэвчин өнгөрүүлж билээ.

Ингээд суралцаж байх хугацаандаа анхны хайрттайгаа 16-н насандаа танилцсан бөгөөд бид хамтдаа циркт ажилладаг байлаа. Тэр их царайлаг, хүчирхэг, сэтгэл булаам залуу байсан. Би одоо л намайг аюулгүй байлгаж чадах хүн оллоо гэж бодсон. Би гэрлэх тухайгаа бусадтай хуваалцахад ээж, циркийн захирал хоёр түүнийг сайн нөхөр болж чадахгүй гэж анхааруулсан. Гэхдээ би түүнд хайртай болсон учраас тэдний анхааруулгыг тоогоогүй өнгөрсөн. Гэвч тэдний зөв байсан.

Бид хуримаа хийж, амьдрал эхэндээ сайхан байсан. Гэрлээд удаагүй байтал бор дарсанд дурлан, үе үе зодох болж, айдастай амьдрал минь эхэлсэндээ. Тухайн үед Монголд хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг хамгаалах байр байхгүй байсан. Тэр намайг зодож эрүүг минь хугалсны дараа би зугатах гэж оролдсон ч зодоод буцаагаад гэртээ авчирдаг байсан.

Хүмүүст өөрчлөгдөнө гэж амласан ч хэзээ ч түүндээ хүрч байгаагүй. Надад туслах хүн байгаагүй учир аймшигт 7-н жилийг өвдөлт дарамттай өнгөрүүлсэн. Би ганцаардаж, маш их сэтгэлээр унаж байсан. Гэхдээ би хүүгийнхээ төлөө амьдрах хэрэгтэй байсан.

Нэг өдөр АНУ-ын циркийн жүжигчид Монголд ирсэн. Тэд миний тоглолтыг сонгож, тэдэнтэй хамт АНУ-д очиж 2 жил тоглолт хийх санал тавьсан. Би ч зөвшөөрсөн. Гэхдээ 5-н настай хүүгээ орхиж явахгүй гэдгээ хэлсэн. Ямар эх хүн хүүгээ хүчирхийллийн дунд орхиод явах билээ. Аз болоход тэд миний хүсэлтийг зөвшөөрсөн. Ингэж доромжлол гутамшиг, хүчирхийлэл мэдэрсэн 7 жил минь төгсгөл болсон юм.

Би хүүгийнхээ болон өөрийнхөө төлөө шинэ, аюулгүй, аз жаргалтай амьдралыг эхлүүлсэн. Өнөөдөр би хүүдээ эмэгтэйчүүд болон хүүхдүүдтэй яаж зөв харьцахыг зааж өгч байна. Тэр минь бусадтай их эелдэг, зөөлөн, хүндэтгэлтэй харьцдаг. Бид одоо л үе дамжсан гэр бүлийн хүчирхийллээс салж чадлаа. Би үүгээрээ их бахархдаг. Өөрийн биеэр туулж өнгөрүүлсэн тэр амьдралаар минь одоо ч хүмүүс амьдарч байгааг харахад сэтгэл үнэхээр их өвддөг.

Монголчууд бид үр хүүхдүүдээ багаас нь зөв хүмүүжүүлж, хүчирхийлэгч бус, бусдыг хайрлаж энэрч, хамгаалдаг хүмүүс болгон өсгөх учиртай.

Мөн хүчирхийллийг өөгшүүлэгч бус, үүнийг зогсоохын төлөө тэмцэгч байж, хөршөө өөрийн адил хайрладаг байхыг уриалж байна.

Одоо би АНУ-д ажиллаж, амьдардаг мэргэжлийн циркийн жүжигчин, багшаар ажиллаж байгаа 50-н настай аз жаргалтай хүчирхэг, үзэсгэлэнтэй, ухаалаг Монгол эмэгтэй болсон. Миний инээмсэглэл чин сэтгэлийнх, би өөрийнхөө үнэ цэнийг ойлгож ухаарсан агаад одоо хэн ч надтай хүч хэрэглэн харьцах ёсгүйг ойлгосон.

Хүнд хэцүү нөхцөлд амьдарч буй эмэгтэйчүүд та бүхэн бүгд үзэсгэлэнтэй, хайрыг хүртэх эрхтэй. Өөрт чинь тийм их зориг, хүч нуугдаж байгаа. Өөртөө итгээрэй. Өөрийнхөө болон үр хүүхдүүдийнхээ төлөө ухаалаг байж чадна. Тэмцэл хэзээ ч оройтохгүй шүү.



АМЬ ДҮЙСЭН ТЭМЦЭЛ

Хүнд хэцүү амьдрал дунд ээж минь намайг эцэггүй хүүхэд нэртэйгээр 1983 онд төрүүлсэн билээ. Ээж минь эмэгтэй хүний туяхан биед үүрч даахгүй хүнд ачаанаас болж ном, кино хоёроос салахаа больж сэтгэцийн өвчтэй болсон юм. Тэр зохиолын баатруудтай ганцаараа ярьж, гуйлга гуйн амьдарсаар бид зах зээлийн хүнд үеийг туулав.

Сумын бүх тэнэгдүү эрэгтэй хүмүүсийг чиний аав чинь байна гэж шоглуулах надад ямар хэцүү байсан гээч. Туйлын ядуу амьдралын эрхээр айл болгоны үүдийг сахин, ганц аяга хоол олж идэн өдрийг өнгөрөөнө. Буяны ажил, дайллага цайллага хаана л болно, тэнд үүдээр нь гүйж дуудаж хоол өгөхийг нь тэсэн ядан хүлээдэгсэн. Галдаа түлэх ганц ч мод байхгүй тул айлын түлээнээс шөнөжин хулгай хийж, сүүлдээ гэрийнхээ шал сандал ширээг түлж, битүү хүүрэг савссан гэрт өдөржин бүжиглэж дулаацан өнгөрүүлдэгсэн.

Асран хамгаалах нэг ч хүн байхгүй 10 настай 2 настай дүү бид 2 яг нохойн гөлөг шиг гүйж явсаар хүн болсон доо. Ширээ дүүрэн гоё гоё хоол идэж байна гэж төсөөлөн хөнжил дотроо

удаан хэвтдэгсэн. Одоогоор бясалгал хийж байсан бололтой. Сумын хогийн цэгийн бүхий л төмөр, хөнгөн цагаан, зэс утсыг түүж, заран гурилтай залгаж дүүгээ харангасаж ухаан алдаж унахаас нь өмнө шаартай цай ум хумгүй ам руу нь хийдэгсэн. Бид хоёрыг ээлжилж хооллож байсан эргэн тойрны хөрш айлууддаа одоо болтол талархдаг.

Ангийн охины ТҮЦ-нд ажиллах санал ирснээр анх наймаа хийх аргад суралцаж, хүнээс 5000 төгрөг зээлээд мөнгө өсгөж үржүүлэх ажил маань эхэлсэн юм. Ингээд хөдөлмөрлөсний эцэст дэлгүүртэй болж цаашлаад өөрийн гэх гэр оронтой боллоо. Амьдрал ч жигдрээд сайхан болж 20-н настайдаа сумын хөдөлмөрийн аварга боллоо.

Ингээд сураг алдарсан төрсөн эгчээ олж дэлгүүрээ хариуцуулж өгөөд өөрөө их сургуулийн хуулийн ангийн оюутан болсон юм. Тухайн үедээ нэгэн даргын хүүтэй танилцаж, бүхий л зүйлсээ зориулсаар түүнтэйгээ суусан юм. Удахгүй анхны хүүгээ төрүүлж амьдрал сайхан байсан ч гар хүрч, завхайрч, цус нөж асгартал зодох болов. Амь дүйн гараас нь

мултарч эмч нарын гарт очиход гайхашран хүлээн авдагсан. Сүүлдээ харааны чадвар алдалт 70% болж группийн зэрэг тогтоолгов. Ингээд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв хэмээх хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалах төв байдаг мэдээлэл авч очсон нь миний амьдралдаа хийсэн хамгийн зөв алхам байлаа.

Харанхуй амьдралд минь гэрэл болон ирсэн энэ байгууллагын ажилчдын харилцаа хандлага, мэргэжлийн туслалцаа нь амьдралд минь үнэлж баршгүй хувь нэмрийг өгсөн. Эрүүл мэнд, сэтгэл зүйгээрээ хохирон байж, тэвчиж өнгөрүүлсэн 15-н жилийн амьдралаас би олон гашуун сургамж авсан.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн хүн заналхийлэх, гутаан доромжлох, бие махбодод хүнд гэмтэл учруулах, хүчирхийлэх айлган сүрдүүлэх, амь насанд халдах, бусдын амийг хорлоход хүргэх гэх мэт олон хуулийн заалтууд нэгхэн сүбъект дээр үйлдэгддэг байсан. Энэ олон гэмт хэргийн үйлдлийг нэг амь яаж дийлэх вэ? Тэр тусмаа нүдэнд харагдаж гарт баригдах боломжгүй сэтгэл санааны хохирлыг хэн ч нөхөн төлдөггүй. Эхээс төрсөн

үнэт биеийг минь хайрлан, тордож халамжлан энхрийлэх үүрэгтэй, нэгэн биений минь нэг тал болсон хань ижлээсээ доромжлол харгислалыг хүртэх дэндүү шударга бус, бас эмгэнэлтэй. Тиймээс энэ бүхнийг төгсгөл болгохоор шүүхэд хандан гэрлэлтээ цуцлуулж, хүүхдийнхээ тэтгэмжийг тогтоолгосон билээ.

Ийм шударга бусын золиосонд олон эмэгтэйчүүд битгий өртөөсэй. Амьдрал чинь харанхуй бүүдгэр байсан ч сэтгэл зүрх найдварын гэрлээ бүү унтраагаасай. Бүхнийг зогсоож шинэ амьдрал эхлүүлэх зоригтой, бас хүчтэй байгаарай эмэгтэйчүүд минь. Чамайг нэгэнт хайрлахгүй байгаа нэгний сэтгэлээс халамж анхаарал хүсэх нь яг л хоосон хөндий онгорхой савыг дүүргэх гэж зүтгэхтэй адил юм билээ.

Одоо би хүүхдүүдтэйгээ сэтгэл амар, тэднийгээ сургууль цэцэрлэгт зөөн ХЭҮТ-ийн хамт олны бэлэглэсэн гэрт амар тайван амьдарч байна. Хүчирхийлэлд өртөж байвал эд хөрөнгө, нэр төр энэ бүхэн зүрх сэтгэлийн хоосон орон зайг нөхөхгүй юм билээ.



ЭРСДЭЛ ДЭХ ЭЛЭГ БҮТЭН АМЬДРАЛ ЧУХАЛ УУ?

Нөхөр бид хоёр анх 2010 онд айл гэр болж байлаа. 2011 онд анхны хүүхэд маань төрж ээж болсон тэр шөнө миний амьдралын хамгийн жаргалтай мөч байв. Нөхөр маань надаас 7 насаар ах, анхаарал халамж сайтай нягт нямбай хүн байсан юм. Бид хадам ээжтэйгээ хамт амьдардаг байлаа. Хадам ээж анхнаасаа л надад таагүй хандаж, хийсэн бүхнийг минь өөнтөглөж гоочилдог байв.

Төд удалгүй хадмын зүгээс ирэх дайралт, буруутгал, шүүмжлэл нэмэгдэж эхэлсэн. Хожим мэдэхнээ хүүгээ баян эмэгтэйтэй суулгах гэж байхад хүү нь надтай учирсан тул надад үргэлж таагүй ханддаг байж. Олон удаагийн дайралт доромжлолыг нөхөртөө хэлэлгүй, ээж хүү хоёрын харилцаанд сэв суулгахгүй гэсэндээ чимээгүй өнгөрүүлж байлаа. Ийм байдалтайгаар амьдрал үргэлжилсээр 4 дараалан ойрхон төрж алдарт эх боллоо. Энэ бүхэн хадам ээжид маань маш хүндээр тусдаг байлаа.

Миний утсанд хадам ээжээс нөхрөөсөө сал гэсэн мессэжүүд ирэх болов. Энэ тухай нөхөртэйгээ ярилцахаар орцонд ортол манай нөхөр үгийн зөрөөгүй хүчтэй алгадахад нь би суун тусаж унах зуур намайг шатны бариултай толгой хавсаргаж дахин 1 удаа цохив. Би толгой дүүрч шуугиад манарч суутал, урт үсийг минь гартаа ороогоод шатны уруу чирлээ, хоёр хөлний нь үзүүр нүдэнд гялалзан харагдаж байсан. Гараас нь мултрах гээд ч чадал хүрэхгүй 9-өөс 7-н давхар хүртэл чирүүлсэн. Азаар битүүний өглөө учир 7 давхрын айлаас нэг хүн санамсаргүй гарч таараад би сая нэг гараас нь мултарч гэр лүүгээ гүйж орлоо. Энэ бүх үйл явдлыг хадам ээж, ах хоёул гэрийн хаалгаар харж зогссон атлаа Болиоч! гэж хэн нь ч дуугараагүй нь дэндүү аймшигтай. Төд удалгүй нөхө араас орж ирэн хутга барьж, сэрээгээр нүүрийг минь сийчсэн юм. Энэ бүхэнд хадам ээж юу ч хийхгүй байлаа.

Би арай гэж 103-т дуудлага өгч гэмтлийн эмнэлэгт очиж үзүүлэхэд хамрын баруун талд цөмөрсөн, тархиндаа гэмтэл авсан байсан. Төд удалгүй бие тэнхэрч хүүхдээ өнчрүүлэхгүй гэсэн бодол толгойд эргэлдэж мөн л уучилсан. Үүний дараахан намайг ална хэмээн айлгаж сүрдүүлэхэд нь би амжиж угаалгын өрөөндөө орж 102-т дуудлага өглөө. Цагдаа ч маш хурдан ирлээ. Тэр хооронд угаалгын өрөөний хаалганы цоож, боолтыг гадна талаас нь тайлж түгжээг хөших үед хадам ээжээс тусламж хүсэн зөндөө дуудсан ч гарч ирээгүй юм. Цагдаа орж ирээд авч явсны дараа хадам ээжийн дарамт улам нэмэгдсэн.

Ингээд энэ бүхнийг тэвчихээ больж ахындаа очиж бүх үнэнээ хэлдээ. Бэр эгч маань намайг дагуулаад Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд очсон юм.

Би ганцаараа ийм зовлонтой амьдраагүйгээ ойлгосон. Тэнд маш олон эмэгтэйчүүд үйлчилгээ авч, хамгаалах байранд нь амьдарч байлаа. Удаан жилийн хүчирхийллийг тэвчсэнээс сайн үр дүн хүлээх хэрэггүйг ойлгосон. Нэг бол амь насаа алдаж эсвэл тахир дутуу, эрүүл мэнд

зүрхсэтгэлээрээ хохирохыг тус төвийн мэргэжилтнүүд ойлгуулж өгсөнд одоо болтол баярлаж байдаг. Би цагдаагийн байгууллагад хандаж, шүүх нөхөрт маань 2.5 жилийн тэнсэн харгалзах ял өгч, хүүхдүүдийн асрамжийн асуудал шийдэгдсэн билээ.

Ингээд ажил идэвхтэй хайсны үр дүнд нэг худалдааны төвд зохион байгуулагчаар ажилд орж төд удалгүй гүйцэтгэх захирлаар томилогдож байгууллагынхаа шилдэг ажилтнаар шалгарсан. Дараа нь би ажлынхаа газрын хажуухан талд цайны газар нээж амжилттай ажилласан. Би өдөр ирэх тусам өөртөө илүү итгэлтэй, хүчирхэг болж байгаагаа мэдэрдэг.

Эмэгтэйчүүд бид зориглож олон жилийн хүчирхийлэл дарамтыг зогсоож, түүнийг даван гарч чадвал бидэнд амжилтанд хүрэх бүхий л боломж бий. Хүүхдүүдэд маань яг ямар аав хэрэгтэйг санаарай. Элэг бүтэн амьдралын дор тэд маань үнэхээр жаргалтай, аюулгүй, амар тайван амьдарч байна уу? гэдгийг эргэцүүлэн, илүү өргөн бөгөөд ухаалаг дүгнэлтийг та бүхэн минь хийгээрэй.





ХҮҮХЭД БУРУУГУЙ...


Би 32 настай, нөхөр 2 хүүхдийн хамт Улаанбаатарт амьдардаг. Би нөхөртэйгээ 2000-2007 он хүртэл 7 жил хамт амьдарсан. Бид 2 хүүхдийнхээ хамтаар хадмындаа амьдардаг байсан болохоор байдал нэлээд хэцүү л байсан. Тэр үед би цайны газар ажилладаг байсан болохоор ажил ихтэй тул байнга оройтож тарна. Иймээс нөхөр маань хүүхдүүдээ цэцэрлэгээс авдаг байсан. Нөхөр үүндээ ихэд бухимдаж, хүүхдүүддээ уураа гаргаж, зоддог байсан.

Би тэд “буруугүй ш дээ” гэж хэлэхэд тэр миний үгийг үл хайхран намайг бас зодно. Чиний ажил хийдэг чинь надад хамаагүй, би өрхийн тэргүүн гэрийн эзэн гэдгийг ойлгох хэрэгтэй гэдэг байсан. Би энэ байдлаас яаж гарахаа мэдэхгүй хадам эцэг эх, ах эгч нартаа хандсан хэдий ч тэд “чиний л буруу шүү дээ” гэсэн хариуг өгдөг байлаа.

Ингээд би мухардаж хаана хандахаа мэдэхгүй хэсэг байсан. Түүнд учир шалтгаангүй зодуулсаар байгаад

би хайртай хэдий ч сэтгэлд дулаан зүйл үлдээгүй учраас итгэхээ больж салахаар шийдсэн.

Шийдвэр гаргасныхаа дараа ах эгч нар руугаа болон нөхрийнхөө хамаатнууд руу утасдаж манайд ирээч гэж гуйсан боловч хадмын талаас хэн ч ирээгүй. Харин манай ах эгч хоёр ирээд бүх зүйлийг сонссон. Би хоёр хүүхдээ аваад эгчийндээ очиж хамт амьдрах болсон. Гэхдээ би эгчдээ гэр бүлийнхээ хүчирхийллийн талаар хэлдэггүй байсан, ярих ч чадалгүй байсан. Миний хувьд энэ маш том нууц байдаг байсан гэхүү дээ. Хувцсаар минь хоолой боож, багалзуурдаж хөхрүүлдэг ба би биеэрээ дүүрэн хөх няц болоод явдаг байсан болохоор түүнийгээ нууж байнга хүзүүтэй цамц өмсдөг байлаа. Би нөхрөөсөө салсныхаа дараа ажлынхантайгаа тэр байтугай даргатайгаа болон бусад хүмүүстэй энэ асуудлаар чөлөөтэй ярьж чаддаг болсон.



Тэд энэ тухайгаа нууж явсан нь буруу гэж надад хэлсэн. Ажлынхан маань намайг өглөө ирэхдээ л уйлаад бөлцийчихсэн байдаг байсныг, энд тэндээ хөхөрснийг олж харсан байдаг байж. Би ажил дээрээ хэзээ ч уйлж байгаагүй ч шөнөжингөө зодуулж уйлдаг байсан. Тэд ямар нэг юм болохгүй гэдгийг мэддэг байсан юм байна лээ. Надаас “яасан бэ” гэхээр “их унтчихжээ” гэж хариулдаг байлаа. Харин тэдэнтэй ярихад би ганцаархнаа тийм асуудалтай биш байсан ба нөхрөөсөө салсан хүмүүс ч бас байсан. Ажлынхан маань намайг маш их дэмжиж тусалсан даа.

Би дахин гэрлэж амьдралаа шинээр эхэлүүлсэн. Одоо гурван настай хүүхэдтэй. Би сэтгэл санааны дарамттай харилцаанд байхаа больсон. Хааяа хүүхдүүд маань эцэгтэйгээ уулздаг ч тэр энэ бүх асуудалд хүүхдүүд буруутай гэж үздэг хэвээрээ л байгаа. Тэр хүүхдүүдтэйгээ уулзах гэж байнга ирдэггүй, шүүхийн тогтоол гарсан учир тэтгэлэг төлдөг. Хааяа хүүхдүүдийн ном дэвтэр гээд мөнгө хүрэлцэхгүй хэцүү л байдаг.

Дахин хүнтэй сууна гэдэг бас л жаахан бэрхшээлтэй байсан. Гэхдээ би одоо сайн нөхөртэй. Тэр намайг сайн ойлгодог, хуучин нөхөртэйгээ байхад минь ч надад тусалдаг байсан учраас түүнд итгэдэг.

Миний хувьд илүү дээр амьдрал байдаг юм байна гэдгийг мэддэг болсон ба амьдралаа сайжруулж чадна гэдэгтээ итгэл дүүрэн байна.



Даван туулаг
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
түүх